



ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын харьяа Хэнтий аймгийн Аудитын газрын 2015 оны төлөвлөгөөний дагуу хийсэн НИЙЦЛИЙН АУДИТ

“ХЭНТИЙ-УС” ХХК-ИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ АЛДАГДСАН БАЙНА.

Зохион байгуулалтын нэгж: **НИЙЦЛИЙН АУДИТЫН БАГ**

Аудитын код: ХЭТ/2015/01-НА

Аудитын нэр: “Хэнтий-Ус ХХК-ний 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа”

ЧИНГИС хот
2015 он

АГУУЛГА

ХЭТ/2015/01-НА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Хэнтий аймгийн аудитын газар Аймгийн тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин Аудитын менежер Б.Наранцэцэг Ахлах аудитор Н.Туяа Аудитор Ү.Төгсжаргал Шинжээч Б.Мөнгөнцэцэг 2015 оны 09 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70562147 дугаарын утас, 70562112 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Хэнтий аймаг Хэрлэн сум Аймгийн ЗДТГ-ын байр 315 тоот	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..... 3 Бүлэг 1 БАЙГУУЛЛАГЫН ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭР ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА. Татварын алба Хэнтий-Ус” ХХК-нийг хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлд өмчийн хэлбэрийг ХУВИЙН, үүсгэн байгуулагч нь НЭГ гэж бүртгэж, байгууллагын өмчлөлийн хэлбэрийг алдагдуулан компаний тухай хууль болон аймгийн ИТХ-ын 2001 оны тогтоолын заалтыг зөрчсөн байна.. “Хэнтий Ус” ХХК-ний эрх бүхий албан тушаалтан болох төлөөлөн удирдах зөвлөлд орон нутгийн өмчийн төлөөлөгч байхгүй, даргаар аймгийн ИТХ-ын дарга ажиллаж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна. Бүлэг 2 ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ЗАРЦУУЛАЛТЫН АНХАН ШАТНЫ БАРИМТЫГ БҮРЭН БҮРДҮҮЛЭЭГҮЙ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА. Шатахуунд бэлнээр зарцуулсан гэх 55,3 сая төгрөгийн шатахууны зарцуулалт тодорхойгүй, шууд зардалд хаажээ.. Бүлэг 3 92,9 САЯ ТӨГРӨГИЙН БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРЦУУЛАЛТ НОТЛОГДОХГҮЙ БАЙНА. - Их засвар хийгдээгүй 7-р зуухны барилгын өртгийг 40,6 сая төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдүүлэн бүртгэснээс гадна 52,3 сая төгрөгөөр хөрөнгийг нотлох баримтгүйгээр капиталжуулан бүртгэсэн нь холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй байна. Бүлэг 4 ЭД ХАРИУЦАГЧ БАРАА МАТЕРИАЛЫН ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГААГҮЙ, АНХАН ШАТНЫ БАРИМТ ДУТУУ, ТАТВАРЫН ТАЙЛАН ЗӨРҮҮТЭЙ ЗЭРЭГ ЗӨРЧЛҮҮД НЬ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ӨР, АВЛАГЫГ ҮНЭН ЗӨВ ТУСГАСАН ЭСЭХИЙГ НОТЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОЖ БАЙНА. 2014 оны эцэст санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл 40,8 сая төгрөгөөр, өглөгийн үлдэгдэл 166,0
---	--

	сая төгрөгөөр буурсан ч цэвэр бохир ус, халаалтын төлбөрийг хугацаандаа барагдуулж ажиллах шаардлагатай байна. Бүлэг 5 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. • Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх ажил учир дутагдалтай бөгөөд зарим хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулж байна. • Хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллах шаардлагатай болсон байна. Бүлэг 6 Байгууллагын дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. • Хэнтий-Ус ХХК-ийн хөрөнгө мөнгө, бараа материалын зарцуулалтад тавих байгууллагын дотоод хяналт алдагдаж, хөрөнгө үрэгдэх, шамшигдах нөхцөл боломж үүссэн байна. Дүгнэлт..... Зөвлөмж..... Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

ТАНИЛЦУУЛГА, АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

Аймгийн Аудитын газрын үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний дагуу “Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа ” –нд нийцлийн аудитыг аудитын менежер Б.Наранцэцэг хянан удирдаж, ахлах аудитор Н.Туяа аудитын багийг ахлан аудитор Ү.Төгсжаргал, шинжээч Б.Мөнгөнцэцэг нар 2015 оны 06 дугаар сарын 02-наас 09 дүгээр сарын 17-нд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт: Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд:

- **Байгууллагын өмчлөлийн хэлбэр эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байна уу?**
- **Шатах тослох материалын 2014 оны зарцуулалтыг үнэн зөв тайлагнасан байна уу?** /Санхүүгийн дүн 302,3 сая төгрөг/
- **2014 онд капиталжуулсан 326.0 сая төгрөгийн их засварын ажлын баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байна уу?** /Санхүүгийн дүн 326.0 сая төгрөг/
- **Өр авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан байна уу?** /Авлага 235.7 сая төгрөг, өр төлбөр 364,7 сая төгрөг/
- **Үндсэн хөрөнгийн худалдан авалт, хадгалалт хамгаалалт хууль журмын дагуу хийгдэж байна уу?** /Нийт үндсэн хөрөнгө 5306,4 сая төгрөг/

гэсэн асуултуудад хариулт өгөх зорилтын хүрээнд аудит хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, санал, зөвлөмж боловсруулан хууль тогтоомжийн дагуу холбогдох албан тушаалтанд танилцуулах, тайланг хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Аудитаар шалгагдах асуудлын санхүүгийн нийт үнэлгээ 6299,7 сая төгрөг бөгөөд аудитаар хүлээн зөвшөөрхүйц алдааны материаллаг хэмжээг 2 %-р буюу нийт 126,0 сая төгрөгөөр тооцов.

Хамарсан хүрээ

Аудитад Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны касс харилцахын баримт, аж ахуйн баримт, халаалт ус нийлүүлэх байгууллагуудтай хийсэн гэрээ, банкны зээлийн гэрээ, журнал, ерөнхий дэвтэр, хөрөнгийн худалдан авах гэрээ, санхүүгийн тайлан, Орон нутгийн өмчийн албаны шийдвэр, аймгийн ИТХ-ын шийдвэр, байгууллагын даргын тушаал, байгууллагын үйл ажиллагааны тайлан зэрэг холбогдох баримт материалыг хамруулав.

Арга зүй

Аудитад зарим албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох судалгаа авч нэгтгэн дүн шинжилгээ хийх, анхан шатны баримттай тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын 4200 стандартад заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг аудитын ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараахь хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгов.Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компаний тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм, журам, бусад холбогдох эрх зүйн актууд

Компанийн дүрэмд:

1.1. Хэнтий-Ус ХХК нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани мөн.

1.4. Хэнтий-Ус ХХК-ийн өмчлөгч нь төр байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн алба байна.” гэж заасан байна.

4.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь нийтийн аж ахуй үйлчилгээг хүн бүрт чанартай хүртээмжтэй хүргэн ажиллахад оршино.

4.2 Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Усан хангамж, ариутгал татуурга, дулаан хангамж, нийтийн халуун ус, барилга засвар үйлчилгээ юм.” гэж заасан байна.

Аудитын газар нь Хэнтий-Ус ХХК-ний 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж нягтлан бодох бүртгэлийг хангалтгүй хөтөлсөн, хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, өглөг, авлагын үлдэгдлийг бүрэн баталгаажуулаагүй, НББ-д тусгагдсан өр, авлага нь үнэн зөв тусгагдсан эсэх нь нотлогдохгүй зэрэг зөрчил илэрсэн тул “ Дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна.

Энэ удаагийн нийцлийн аудитаар: Хэнтий-Ус ХХК-ний өмчлөлийн хэлбэр эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн эсэх, шатах тослох материалын зарцуулалт болон капиталжуулсан хөрөнгүүдийг үндсэн баримтуудын дагуу үнэн зөв тайлагнасан эсэх, өр авлагыг үнэн зөв бүртгэсэн эсэх, үндсэн хөрөнгийн худалдан авалт, хадгалалт хамгаалалтыг хууль журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх гэсэн асуудлуудын хүрээнд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨТ хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох заавар журмын нөхцлийг дагаж мөрдсөн эсэхэд аудитыг хийлээ.

1.1 Татварын алба Хэнтий-Ус” ХХК-нийг хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлд өмчийн хэлбэрийг ХУВИЙН, үүсгэн байгуулагч нь НЭГ гэж бүртгэж, байгууллагын өмчлөлийн хэлбэрийг алдагдуулан компаний тухай хууль болон аймгийн ИТХ-ын 2001 оны тогтоолын заалтыг зөрчсөн байна..

ТБОНӨ-ийн тухай хуульд заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд аймгийн ИТХурал 2001 онд Орон нутгийн өмчит “Ус суваг, орон сууц ашиглалтын газар”-ыг өөрчлөн “Хэнтий-Ус” Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах шийдвэр гаргажээ.

“ Компанийн тухай “ хуулийн 12.5.2 дахь заалтад Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулах замаар үүсгэн байгуулсан тохиолдолд төрийн өмчит компанийн үүсгэн байгуулагч болон эзэмшигч нь төр байна гэж заажээ.

Гэтэл “Хэнтий Ус” ХХК-ийн дүрэмд өмчлөгч нь “төр” байна гэж заасан боловч Хуулийн этгээдийн бүртгэлийн 2007 оны шинэчилсэн бүртгэлд компанийн өмчийн хэлбэрийг “хувийн” гэж бүртгэсэн байна.

Хуулийн этгээдийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад “Хэнтий Ус” ХХК-ийг шинэчилсэн бүртгэлд бүртгэхдээ Татварын албаны улсын байцаагч: хуулийн этгээдийг байгуулсан арга замыг “шинээр”, өмчийн хэлбэрийг “хувийн”, үүсгэн байгуулагч нь “нэг” гэж бүртгэн, шинээр үүсгэн байгуулж буй 100% хувийн өмчтэй компани мэтээр бүртгэж бүртгэлийн алдаа гаргасан байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтаас 2007 оны шинэчилсэн бүртгэлийн үндэслэсэн баримт, шийдвэрийн лавлагаа авахаар хүсэлт гаргасан боловч баримт байхгүй тухай албан бичигт дурдсан.

Улсын бүртгэлийн архивын лавлагаа, холбогдох байгууллагын шийдвэр зэргийг нягтлан судлаж, холбогдох хүмүүстэй уулзаж тодруулсны үндсэн дээр тодорхой нөхцөл шаардлагын улмаас Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон бүртгэсэн болох нь тогтоогдож байна. Үүнд:

1. Азийн хөгжлийн банкны зээлээр 2001 онд Зүүн 5 аймагт хэрэгжсэн 20,0 сая долларын өртөгтэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй /Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2-р төсөл / төслийг хэрэгжүүлэх болсон.
2. Азийн хөгжлийн банкнаас төсөл хэрэгжүүлэх байгууллагад 2 үндсэн шаардлага тавьсан.
 - Нэгдүгээрт: Төсөл хэрэгжүүлэх байгууллагын нэр нь компани байх- Банкны шаардлага болон улсын хэмжээнд нэгдсэн журмаар Нийтийн аж ахуй үйлчилгээний газруудыг компани болгож өөрчлөх чиглэл өгсний дагуу ХХК

болгож өөрчлөхөд хүрсэн. Банкны шаардлагад нийцүүлэхийн тулд “Ус суваг орон сууц ашиглалтын газар”-ыг ХХК болгож өөрчлөх эсхүл төслөө буцаах гэсэн 2 сонголт байсны улмаас төслийг буцаалгүй хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий байгууллага болох аймгийн ИТХ-аар ХХК болгож өөрчлөх шийдвэр гаргуулсан байна.

- Хоёрдугаарт: Менежментийн гэрээтэй байх – Энэ шаардлагын үүднээс дарга, Ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч 3 менежментийн багийг бүрдүүлж аймгийн Засаг даргатай менежментийн гэрээ байгуулсан байна. Тухайн үед ХХКомпанийн үндсэн хөрөнгө дээр Менежментийн багийн гишүүдээс тус бүр 1.0 сая төгрөг гаргуулж, нийт 3.0 сая төгрөгийг зээлийн барьцаанд тавьсан байна.

Тус компанийн үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Компанийн тухай хуулиар зохицуулагдаж ирсэн байна.

1.2 “Хэнтий Ус” ХХК-ний эрх бүхий албан тушаалтан болох төлөөлөн удирдах зөвлөлд орон нутгийн өмчийн төлөөлөгч байхгүй, даргаар аймгийн ИТХ-ын дарга ажиллаж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77.4 дугаар зүйлд “.... хурлын Тэргүүлэгчид нь орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.” гэж заажээ.

Мөн хуулийн 21.3-т “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хуралд төрийг төлөөлж оролцохоор томилогдсон төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон байна” гэж зааснаар төрийн өмчийн төлөөлөл нь /Орон нутгийн өмчийн алба/ ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орж ажиллахаар байна.

Гэтэл аймгийн ИТХТ-ийн 2014 оны 50 дугаар тогтоолоор баталсан Хэнтий-Ус ХХК-ийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” шийдвэрт Орон нутгийн өмчийн албаны төлөөлөлийг бүрэлдэхүүнээс хассан нь дээрхи хуулийн заалттай нийцээгүй байна.

Мөн нь Компанийн тухай хуулийн 84.3.1 дэхь “ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд эрх бүхий албан тушаалд төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан ажиллахыг хориглоно “ гэж заажээ.

Гэтэл аймгийн ИТХ-ын дарга “Хэнтий Ус” ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж, компаний эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргаж байгаа аймгийн ИТХ-аас тавих хяналтыг алдагдуулж байгаа бөгөөд дээрхи хуулийн заалтуудтай нийцээгүй байна.

2.1 Шатахуунд бэлнээр зарцуулсан гэх 55,3 сая төгрөгийн шатахууны зарцуулалт тодорхойгүй, шууд зардалд хаажээ.

Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны касс, харилцахын гүйлгээнээс шатахууны зардлыг тулган шалгахад харилцахаас 198.0 сая, касснаас 104.3 сая, нийт 302.3 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна. Үүнээс 6,7,8 саруудад кассаас бэлнээр олгосон нийт 55.3 сая төгрөгийг шатахуун авахад зарцуулсан гэх боловч шатахууны зарцуулалтын анхан шатны баримт байхгүй, хаана, юунд зарцуулсан нь тодорхойгүй, ерөнхий нягтлан бодогч холбогдох хүмүүстэй тооцоо хийж, нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгэлгүй шууд зардалд хаасан байна.

Тус байгууллага нь жолооч бүрээр талон болон бэлэн мөнгөөр шатахуун олгодог боловч, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж ажилладаггүй, тухайн жолооч ямар ажлаар хаашаа явсан талаарх бүртгэл байхгүй, шаардах хуудас бичээгүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй, тооцоог боддоггүй, автомашины нормыг мөрдөж ажилладаггүй, нярав шатахууны нэрийн тайланг сар бүр гаргаж тайлагнахдаа бараа материалын орлогыг материалын эхний үлдэгдэл гэж андуурч тайлагнасан, нягтлан бодогч нярвын нэрийн тайланг тухай бүр хяналт тавьж тооцоог нь боддоггүй, шууд зардалд хаадаг зэрэг нь санхүүгийн ажилтнуудын ажлын хариуцлага хангалтгүй, дотоод хяналт алдагдсантай холбоотой байна.

3.1 Их засвар хийгдээгүй 7-р зуухны барилгын өртгийг 40,6 сая төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдүүлэн бүртгэснээс гадна 52,3 сая төгрөгөөр хөрөнгийг нотлох баримтгүйгээр капиталжуулан бүртгэсэн нь холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй байна.

2014 онд нийт 326.0 сая төгрөгийн их засварын ажлыг үндсэн хөрөнгөд капиталжуулан бүртгэсэн бөгөөд үүнд барилга байгууламжийн дансанд 8-р зуухны барилгыг 40,0 сая төгрөгөөр, конторын барилгыг 7,6 сая төгрөгөөр, 3-р зуухны барилгыг 44,7 сая төгрөгөөр, 7-р зуухны барилгыг 40,6 сая төгрөгөөр, 4-р халуун усны бассейны барилгыг 119,5 сая төгрөгөөр, Дулааны усан хангамжийн өргөтгөлийг 73,6 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

2014 онд “Хэнтий-Ус” ХХК-ний үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн 2014 оны төлөвлөгөөг гарган, УЗ-ийн даргаар батлуулсан боловч баримтлаж ажиллаагүй, дээрх их засварын ажлууд төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Капиталжуулсан үндсэн хөрөнгөтэй холбоотой баримт материалыг шалгахад Хэнтий-Ус ХХК-ийн хөрөнгөд бүртгүүлэхээр Бэрх хотын орон сууцны 5 байрны зоорийн давхрын сантехникийн шугамын засварын ажлын 73,6 сая төгрөгийн, 4-р халуун усны бассейны барилгыг 119,5 сая төгрөгөөр, Бэрх тосгоны дулааны станцын халаалтын зуухны тоног төхөөрөмжүүдийн засвар 40,0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ, ажлын төсөв, гүйцэтгэл, улсын комисс хүлээн авсан актыг үндэслэн Орон нутгийн өмчийн албаны зөвшөөрлөөр капиталжуулан бүртгэжээ.

Харин өөрийн хөрөнгөөр хийсэн гэх конторын барилгын засварт зарцуулсан 7,6 сая төгрөгийн, 3-р зуухны засварт зарцуулсан 44,7 сая төгрөгийн бараа материалын зарцуулалтын баримт хүчин төгөлдөр бус, гарын үсгийг хуурамчаар үйлдсэнээс гадна 44,7 сая төгрөгийн зарцуулалтын баримтад 10,3 сая төгрөгийн аж ахуйн бараа материал, ном зэрэг зүйлсийг зарлагдсан, түүнчлэн их засвар хийх зураг төсөвгүй, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээ, гүйцэтгэсэн ажлын тайлан, хүлээлцсэн акт зэрэг анхан шатны баримтгүйгээр үндсэн хөрөнгийн үнийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 7.7-д “ Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Мөн 7-р зуухны барилгын өртгийг 40,6 сая төгрөгөөр нэмэгдүүлснийг үзэхэд 2014 онд 7-р зуухад 40,6 сая төгрөгийн их засвар хийгээгүй бөгөөд урсгал засвар хийсэн баримтыг түүвэрлэхэд 10,2 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийгдсэн байна. Дээрхи 40,6 сая төгрөг нь 2012 онд хийгдсэн эрчмийн зүүн талын айлуудын шугам сүлжээний ажлын зардал бөгөөд аймгийн ЗДТГазраас авах авлагаар тусгаж бүртгэсэн байсныг хааж, 7-р зуухны өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлэн бүртгэж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг будлиантуулсан байна.

Дээрхи засваруудад зарцуулсан гэх 1 дүгээр сар, 6 дугаар сарын материалын зарлагын баримтыг үзэхэд их засвартай холбоогүй аж ахуйн хэрэгцээний бараа материалыг зарлагадсан, шаардах хуудасгүй, олгосон шаардах хуудас нь байгууллагын даргын зөвшөөрсөн гарын үсэггүй, 3-р зуухны засварын бүх материалыг ерөнхий инженерийн нэр дээр даргын цохолтгүй зарлагдсан, хэн юунд зарцуулсан нь тодорхойгүй, бараа материалыг байгууллагын даргын зөвшөөрөлгүй, төсөв тооцоогүй, хяналтгүй орлогодож, зарлагаддаг зөрчил илэрсэн нь хөрөнгө, мөнгийг шамшигдуулах нөхцөл боломж үүссэнийг харуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1-т “ Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ.”, 18.1-т “ Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ.” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Үүнээс үзэхэд хөрөнгийг бүртгэхдээ өртгийг зөв тооцдоггүй, нэр төрөл, марк, сери дугаараар бүртгээгүй, үндсэн баримтгүйгээр нягтлан бодох бүртгэл, тайланд тусгадаг

алдаа дутагдал илэрсэн нь нягтлан бодогчид, эд хариуцагч нарын ажлын хариуцлага хангалтгүй байгааг харуулж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

• ЭД ХАРИУЦАГЧ БАРАА МАТЕРИАЛЫН ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГААГҮЙ, АНХАН ШАТНЫ БАРИМТ ДУТУУ, ТАТВАРЫН ТАЙЛАН ЗӨРҮҮТЭЙ ЗЭРЭГ ЗӨРЧЛҮҮД НЬ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ӨР, АВЛАГЫГ ҮНЭН ЗӨВ ТУСГАСАН ЭСЭХИЙГ НОТЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОЖ БАЙНА.

4.1 Авлагын талаар:

2014 онд төсвийн байгууллага болон аж ахуйн нэгжийн 139 байгууллагын цэвэр, бохир усны, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн 65 байгууллагын халаалтын бичилтыг төлсөн мөнгөний баримт, харилцах дансны хуулгуудтай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нэгдсэн эмнэлэг, халдвартын тасаг нь оны эхнээс 3 усны тоолууртай үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 5 сард усны тоолуур эвдэрсэн шалтгаанаар 5,6,7 саруудад цэвэр бохир усны төлбөрт нийт 8695.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байхад өглөгөөр тусгаагүй,

2. Баялаг хурх ХХК-д 4073.8 мянган төгрөгийн цэвэр усны төлбөр гарсан байхад 427.3 мянган төгрөгийг төлөөд үлдсэн 3646.5 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүй байна. Учир нь Баялаг хурх ХХК-ийн эзэмшлийн шугамыг Хэнтий-Ус ХХК нь ашигладаг тул цэвэр усны төлбөрийг төлөхгүй байхаар харилцан тохиролцсон гэж албан тоот хүргүүлсэн байна.

Гэтэл орон нутгийн өмчийн албанаас тухайн хөрөнгийн талаар тодруулахад уг шугам нь Баялаг хурх ХХК-ийн өмч биш төрийн өмч гэж хариу ирүүлсэн тул цаашид энэхүү шугамын асуудлыг шийдвэрлэж цэвэр усны төлбөрийг төлүүлэх талаар аудитын газраас албан шаардлага хүргүүлж байна.

Төсвийн байгууллага нь халаалт, цэвэр, бохир усны төлбөрийг хугацаандаа төлж барагдуулж байхад аж ахуйн нэгж байгууллагууд цаг хугацаандаа төлж барагдуулаагүй, мөн аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллаагүй байхад халаалт цэвэр бохир усны төлбөрт бараа материал худалдан авдаг нь ашиг сонирхол үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Цаашид ямар нэр төрлийн, хэдэн төгрөгийн бараа материалыг аль компаниас авах талаар харилцан тохиролцон гэрээ байгуулж, цэвэр бохир усны төлбөр, халаалтын төлбөрийг цаг хугацаанд нь төлүүлдэг байх талаар ажил зохион байгуулж ажиллах шаардлагатай болсон байна.

4.2 Өглөгийн талаар

Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны нягтлан бодох бүртгэл, журнал, дэлгэрэнгүй бүртгэл, өглөг, авлагын тооцоо нийлсэн акт, мөнгөн хөрөнгө, нүүрсний баримтыг шалгаж үзэхэд:

Хэнтий- Ус ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх 128,0 сая төгрөгийн дансны өглөгийн өрийн үлдэгдлийг баталгаажуулсан эсэхийг үзэхэд Бэрх-Уул ХХК-д 22,5 сая төгрөгийн, Баялаг хурах ХХК-д 14,0 сая төгрөг, Алсын солонго ХХК-д 0,7 сая төгрөг, Нутгийн дэлгүүрт 18,7 сая төгрөг, Уламжлалт анагаах ухааны эмнэлэгт 7,3 сая төгрөг, Дорнын нүүрс ХХК-д 15,0 сая төгрөг, Өндөрхаан СӨХолбоонд 38,6 сая төгрөгийн буюу нийт 116,8 сая төгрөгийн өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Үүнээс 2015 оны 4 сарын байдлаар Уламжлалт анагаах ухааны эмнэлэгт 7,3 сая төгрөгийг төлж барагдуулан, Бэрх-Уул ХХК, Өндөрхаан СӨХолбоонд өгөх өглөгүүд хэвээрээ бусад өглөгүүд нь тодорхой хэмжээгээр буурсан байна.

Хэнтий-Ус ХХК орон сууцны айл өрхөөс СӨХ-ны хураамж болох 5,0 мянган төгрөгийг 2012 оноос 2014 оны 9 сар хүртэл сар бүр хураан авсан бөгөөд 2014 оны эцэст СӨХ-д шилжүүлэх 38,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан байна. СӨХ-ний үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаа тул үйл ажиллагааг нь сайжруулж хурааж авсан уг мөнгийг дансанд нь шилжүүлэх нь зүйтэй байна.

1. 2014 онд Бэрх-Уул ХХК-иас татан авсан нүүрсийг орлогын баримтаар тулган шалгахад нярвын тайлангаар Бэрх-Уул ХХК-иас 17829.6 тн буюу 411,8 сая төгрөгийн нүүрс орлого авсан ба үүнээс 1419,3 тн буюу 32,8 сая төгрөгийн баримт дутуу буюу нүүрс авсан эсэх нь нотлогдохгүй байна.

Мөн дээрх нүүрсийг нягтлан бодох бүртгэлд орлого авахдаа 4675.6 тн буюу 108,0 сая төгрөгийн нүүрсийг орлогоор бүртгээгүй бөгөөд 2012 оны эцэст авсан орлогоор бүртгэсэн 108,0 сая төгрөгийн нүүрсийг 2013 оны 1 дүгээр сард дахин орлогод авч, тооцоог зөрүүлсэн байна. Энэхүү алдааг залруулж 2014 онд Бэрх-Уул ХХК-аас авсан нүүрсийг 108,0 сая төгрөгөөр дутуу орлогодож, Бэрх-Уул ХХК-д өгөх өрийг 22.5 сая төгрөгөөр тооцоо нийлж баталгаажуулсан байна.

2. Дорнын нүүрс ХХК-аас авсан нүүрсийг шалгахад нярвын тайлан болон нягтлан бодох бүртгэлд 9022,1 тн нүүрс орлогоор бүртгэсэн бөгөөд орлогын баримтыг түүвэрлэхэд нийт 9815 тн нүүрсний орлогын баримт байгаагаас 225 тн нүүрс чанарын шаардлага хангаагүй хасагдсныг тооцвол 567,9 тн буюу 11,3 сая төгрөгийн нүүрсний орлогыг бүртгээгүй боловч үүнийг нягтлан бодох бүртгэл болон нярвын тайланд тусгагдах эсэх нь нотлогдохгүй байна.

3.Татварын өглөг, авлагыг Татварын албаны дүнтэй тулган баталгаажуулахад ХХОАТ-ын өглөг 1,9 мянган төгрөгөөр зөрүүтэй, татварын тайлангийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаагүй, жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулаагүй нь нягтлан бодох бүртгэлийн хуулийн 19.1.4 “ **Нягтлан бодогч нь ...**

бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ” гэсэн заалтад нийцээгүй байна.

Дээрхи байдлаас үзэхэд Хэнтий-Ус ХХК нь өмнөх оны эхэнд хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй байсан бөгөөд өр төлбөр, авлагын үлдэгдлийг улирал бүр харилцагч байгууллага, иргэдтэй тооцоог нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримт болон баримтын бүрдэл дутуу, эд хариуцагчийн бараа материалын тайлан болон татварын тайланг үнэн зөв гаргаагүй зэрэг зөрчлүүд нь нягтлан бодох бүртгэлд өр, авлагыг үнэн зөв тусгасан эсэхийг нотлох боломжгүй болгож байна.

ТАВДУГААР
БҮЛЭГ

**• ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ
САЙЖРУУЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

5.1 Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх ажил учир дутагдалтай бөгөөд зарим хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулж байна.

Хэнтий-Ус ХХК нь 2014 онд нийт 1637.9 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэснээс 1545,0 сая төгрөгийн хөрөнгийг зохих баримт, шийдвэрийг үндэслэн бүртгэсэн бол 3,7-р зуухны болон конторын барилгыг нийт 92,9 сая төгрөгийн их засвар хийсэн мэт анхан шатны нотлох баримтгүйгээр өртгийг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Орлого авсан огноо	Харилцагчийн нэр	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	/сая.төгрөгөөр/		
				Нэгжийн үнэ	Нийт үнэ	өртгийг капитал жуулсан
2014.01.01	Хэрлэн сумын ЗДТГазар	Ниймийн бие засах газар	2	20.5	41.0	
2014.01.01	Хэрлэн сумын ЗДТГазар	Хог тээврийн машин	1	23.5	23.5	
2014.01.01	Хэрлэн сумын ЗДТГазар	8-р уурын зуухны барилга		40.0	40.0	40.0
2014.01.01	Эрчим хүчний зохицуулах хороо	Лабаторийн тоног төхөөрөмж	1	23.6	23.6	
2014.01.01	Нийтлэг үйлчилгээний газар	Бохир усны машин 10 тн	1	45.0	45.0	
2014.01.01	Хэрлэн сумын ЗДТГазар	Хогийн цэгийн хашаа	1	9.0	9.0	
2014.01.20	Морин цаг ХХК	Компьютер I7	1	2.5	2.5	
2014/12/31	Би си ти ХХК	Компьютер core-2	4	0.6	2.2	
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	Конторын барилга		7.6	7.6	7.6
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	3-р уурын зуухны барилга		44.7	44.7	44.7
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	7-р уурын зуухны барилга		40.6	40.6	40.6
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	4-р багийн цэвэр усны шугам 2014	1	135.0	135.0	
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	4-р багийн бохир усны шугам 2014	1	59.0	59.0	
2014/12/31	Хэрлэн сумын ЗДТГазар	Хогны машин 2014 он	2	25.0	50.0	
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	4-р баг 20-н айл хаусны шугам	1	332.1	332.1	
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	4-р халуун ус -бассейны барилга		119.5	119.5	119.5
2014/12/31	Хэнтий-Ус ХХК	Дулааны усан хангамжийн өргөтгөл		73.6	73.6	73.6
2014/12/31	УТ-ийн хөрөнгө оруулалт	Гутлын үйлдвэр	1	489.0	489.0	
2014/12/31	Тулга Конштракшин ХХК	Орон сууц	2	50.0	100.0	
		Дүн	0		1637.9	326.0

Үүнд **2012 онд** хийгдсэн орон нутгийн өмчид бүртгэлтэй 489.0 сая төгрөгийн гутлын үйлдвэр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 25.3 сая төгрөгийн цэвэр бохир усны шинжилгээний тоног төхөөрөмж, **2013 онд** орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 41.0 сая төгрөгийн нийтийн бие засах газар, 9.0 сая төгрөгийн хогийн цэгийн хашаа, 40.0 сая төгрөгийн 8-р уурын зуухны барилга, “Орон нутгийн нийтийн аж ахуйн тусгай зориулалтын машин механизм тоног төхөөрөмж” төслөөр ирсэн 45.0 сая төгрөгийн бохирын машин зэрэг 749,3 сая төгрөгийн хөрөнгүүдийг өмнөх онуудад Хэнтий-Ус ХХК-д орлогоор бүртгэх зохих шийдвэр гарсан байхад он дамжуулан 2014 онд орлогоор бүртгэсэн байна.

Мөн НААҮ-ний газраас ирсэн цэвэр, бохир усны шинжилгээний тоног төхөөрөмжийг 9 нэр төрлийн 25.2 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн баримттай байхад орлогод авахдаа нэр төрлөөр биш бөөн дүнгээр нь 23.6 сая төгрөг буюу 1.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн, лабораторийн мэргэжилтэн байхгүйгээс тухайн хөрөнгийг эзэмшиж ашиглах хүн байхгүй, одоо тухайн хөрөнгийг ашиглаагүй, хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Гутлын үйлдвэрийн байранд Хэнтий гутал ХХК, ЗОМБСЭ ХХК гэсэн хоёр аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хэнтий гутал ХХК нь аймгийн Засаг даргатай үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийг ашиглах гэрээ байгуулсан байна. Гэтэл ЗОМБСЭ ХХК нь 2012 онд Хэнтий –Ус ХХК-ийн худалдан авсан 9,2 сая төгрөгийн үнэ бүхий тавилгын тоног төхөөрөмж болон байр ашиглах түрээсийн гэрээ байгуулаагүй, одоог хүртэл төрийн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглаж байгаад эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулж түрээсийн төлбөр авах талаар санаачлага гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг тайлант онд бүртгэж авдаггүй, шинээр ирсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөл акт үйлдэж хүлээж авдаггүй, тайлант онд шаардлагатай хөрөнгийн жагсаалт гаргаж мөрддөггүй, хөрөнгийг нэр төрлөөр нь бүртгэдэггүй, төрийн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулдаг, төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа хөрөнгийн талаарх мэдээлэл дутагдалтай байгаа нь хөрөнгө үрэгдэж, эзэнгүйдэх нөхцлийг бүрдүүлжээ.

5.2 Хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж ажиллах шаардлагатай болсон байна.

Тус байгууллагад 2014 оны жилийн эцэст 6221.9 сая төгрөгийн барилга байгууламж, 360.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 994.7 сая төгрөгийн автотээврийн хэрэгсэл, 131.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, 17.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Аудитаар тус байгууллагын үндсэн хөрөнгийг 2015 оны 9 дүгээр сарын 04-ний байдлаар түүвэрчилсэн тооллого хийх явцад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд 65.6 сая төгрөгийн усны тоолуур, 0.08 сая төгрөгийн байгууллагын албан тоотын бланк, 0.02 сая төгрөгийн уртасгагч залгуур, 0.08 сая

төгрөгийн ус буцалгагч, 0.07 сая төгрөгийн үсний сэнс, 0.07 сая төгрөгийн цаас зүсэгч, 0.1 сая төгрөгийн зузаан толь, 0.4 сая төгрөгийн модон угаалтуур зэрэг бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, одоо тухайн байгууллагад ашиглагдаж байгаа нь тодорхойгүй байна.

2. Хэнтий –Ус ХХК нь 2014 оны жилийн эцсээр 31.5 сая төгрөгийн 32 нэр төрлийн компьютер техник хэрэгслийн үлдэгдэлтэй, 2015 оны 9 сарын байдлаар 23.1 сая төгрөгийн 23 нэр төрлийн компьютер техник хэрэгсэл ажилтан албан хаагчид нь ашиглаж байгаа бөгөөд аймгийн ИТХурлын шийдвэрээр 8.4 сая төгрөгийн 8 нэр төрлийн компьютер техник хэрэгсэл актлах шийдвэр гарсан байхад одоог хүртэл үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй байна.
3. Сургалтын танхимд 5.1 сая төгрөгийн 80 сандал бүртгэлтэй байгаа боловч явцын тооллогоор 19 сандал сургалтын өрөөнд, үлдсэн 61 сандлыг картаар хэнд эзэмшүүлсэн нь тодорхой бус, мөн 2005 онд орлогод авсан 0.4 сая төгрөгийн 2 ширхэг болор гэрлийн бүрхүүлийг одоог хүртэл ашиглаагүй, 0.1 сая төгрөгийн 2 ширхэг өрөөний гэрэл аль өрөөнд тавигдсан нь тодорхойгүй, систем хөгжим, кассын машин, гар ариутгагч, хуушуур шарагч зэрэг нийт 0.8 сая төгрөгийн хөрөнгө эвдэрсэн, компьютер, ширээ, сандал, сейфэнд бүртгэлийн код байхгүйгээс тухайн ажилтны эзэмшиж байгаа хөрөнгө мөн эсэхийг тогтоох боломжгүй байсан, цайны газарт ашиглаж байгаа гал тогооны техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаагүй, агуулах складанд хадгалагдаж байгаа хөрөнгийн эмх цэгц хангалтгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй, цаг хугацаанд нь тооцоог бодож баталгаажуулаагүй, хөрөнгүүдийн шинэ хуучныг ялган ангилаагүйгээс эд хариуцагч өөрөө ч хөрөнгүүдийг таньж ялгахад хүндрэлтэй болсон байна.



Түүвэр тооллого хийх үед агуулахад хадгалагдаж хөрөнгийн байдал

Цаашид актлах шийдвэр гарсан хөрөнгүүдийг актлаж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулж, агуулах складыг эмхлэн цэгцэлж, хөрөнгүүдийг бүртгэлжүүлэн коджуулж, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллах шаардлагатай болсон байна.

6.1 Хэнтий-Ус ХХК-ний хөрөнгө мөнгө, бараа материалын зарцуулалтад тавих байгууллагын дотоод хяналт алдагдаж, хөрөнгө үрэгдэх шамшигдах нөхцөл боломж үүссэн байна.

2014 онд их засвар хийх төсөв тооцоогүй, ажлын гүйцэтгэлийн тайлан нотлох баримтгүй материал зарцуулсан, бараа материалыг байгууллагын даргын зөвшөөрөлгүй, хяналтгүй орлогодож, зарлагаддаг, 9 дүгээр сарын 26 хүртэл шаардах хуудсанд байгууллагын дарга бус ерөнхий инженерийн гарын үсгээр бараа материалыг зарцуулсан, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт хангалтгүй, тооллого тооцоог чанартай зохион байгуулдаггүй, хөрөнгийн тоо ширхэг зөрүүтэй, агуулах склад эмх цэгцгүй, материалыг шууд зардалд хаадаг, нярвын нэрийн тайланг тухай бүр хяналт тавьж тооцоог нь боддоггүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж ажилладаггүй, шатахуун зарцуулалтанд тавих шат шатны дотоод хяналт алдагдсан зэрэг зөрчил дутагдал илэрсэн нь байгууллагын удирдлага зохион байгуулалт болон нягтлан бодогчдын ажлын хариуцлага туйлын хангалтгүй байгаатай холбоотой байна.

ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу дотоод хяналтыг зохион байгуулан ажиллах шаардлагатай байна.

Нийцлийн аудитаар нийт 359,8 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн байна. Аудитын дүнд дараах арга хэмжээг авч ажиллалаа.Үүнд:

1. Хэнтий-Ус ХХК-ийн гүйцэтгэх захиралд:

- Хэнтий-Ус компанийн өмчлөлийн хэлбэрийг хуулийн этгээдийн бүртгэлд “хувийн өмчтэй” гэж бүртгэсэн алдааг залрууулан, бүртгэлийг зөв болгох албан шаардлага хүргүүллээ.
- Өөрийн хөрөнгөөр хийсэн гэх үндсэн баримтгүй капиталжуулсан их засварын 52,3 сая төгрөгийн бараа материалыг их засварт зарцуулсан гэх үндэслэлгүй, 10,3 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан буюу хаана, юунд зарцуулсан нь тодорхойгүй, Дорнын нүүрс ХХК-наас авсан нүүрсний анхан шатны баримтаас 11,3 сая төгрөгийн нүүрсийг орлогоор бүртгэх эсэх нь тодорхойгүй, Баялаг Хурх ХХК-аас 3,6 сая төгрөгийн төлбөрийг дутуу авсан, харилцагч иргэдтэй өглөг авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг 349,6 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

- Нэгдсэн эмнэлгээс цэвэр, бохир усны төлбөрт 8,6 сая төгрөгийг илүү тооцож авсан зөрчилд төлбөрийн актыг тогтоолоо.
- Ажлын хариуцлага алдсан ерөнхий нягтлан бодогч, материалын нягтлан бодогч нарт хариуцлага тооцох санал хүргүүлээ.
- Зөрчил, дутагдлыг залруулж ажиллах талаар 6 зөвлөмж өглөө.

2. Аймгийн ИТХ-д:

- Хэнтий-Ус ХХК-ний Удирдах зөвлөлийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, орон нутгийн өмч болох компаний эд хөрөнгөд ТБОНӨТ хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг зөвлөх.

3. Аймгийн Засаг даргад:

- Хөрөнгийг хяналтгүй зарцуулж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлэх.

4. Эдийн засгийн Цагдаагийн албанд:

- Өөрийн хөрөнгөөр хийсэн гэх 3-р зуухны засварт зарцуулсан 44.7 сая төгрөгийн бараа материалын зарцуулалтын баримт хүчин төгөлдөр бус, гарын үсгийг хуурамчаар үйлдсэн, бэлнээр зарцуулсан 55.3 сая төгрөгийг шатахуун авсан гэх боловч нотлогдоогүй, “Бэрх-Уул” ХХК-ниас авч орлогоор бүртгэсэн нүүрснээс 32.8 сая төгрөгийн нүүрсийг авсан эсэх нь нотлогдохгүй зэрэг нийт 132.8 сая төгрөгийн хөрөнгийг зүй бусаар зарцуулж, байгууллагад хохирол учруулсан байх болзошгүй тул Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

1. Бэлнээр зарцуулсан 55.3 сая төгрөгийг шатахуун авсан гэх боловч шатахууныг хаана, юунд зарцуулсан нь тодорхой бус, анхан шатны үндсэн баримт байхгүй, ерөнхий нягтлан бодогч холбогдох хүмүүстэй тооцоо хийж, авлагаар бүртгээгүй зэрэг нь бэлэн мөнгөний зарцуулалт туйлын хангалтгүй, түүнд тавих дотоодын хяналт алдагдаж, хөрөнгө зүй бусаар үрэгдэж шамшигдахад хүрсэн байгааг харуулж байна.
2. 52.3 сая төгрөгийн аж ахуйн болон бараа материалыг конторын болон 3 дугаар уурын зуухны барилгын засварт зарцуулсан гэх боловч нотлогдоогүй, анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэж, барилгын үнийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн хаасан. Компаний УЗ-өөр баталсан үйлдвэрлэл үйлчилгээний болон санхүүгийн 2014 оны төлөвлөгөөнд барилгын засварын ажлууд тусгагдаагүйн дээр барилгын засварын ажлын төсөв тооцоо, ажил гүйцэтгэсэн тайлан, ажил хүлээж авсан акт байхгүй нь дээрх хөрөнгийг хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байна.
3. Аж ахуй нэгж, байгууллагаас халаалт, цэвэр бохир усны төлбөрт бараа материал авдаг боловч, түүний зарцуулалтын анхан шатны баримт хангалтгүй, нүүрсний орлого, зарлага нь үнэн зөв эсэх нь нотлогдохгүй, бараа материалын тайланг үнэн зөв гаргадаггүй, орлогодсон болон зарлагадсан бараа материалын анхан шатны үндсэн баримтыг хуурамчаар үйлдсэн, бараа материалыг ямар ч хяналт, зөвшөөрөлгүй зарлагдаж, зарцуулалтад тавих шат шатны хяналт орхигдсон нь хөрөнгө зүй бусаар үрэгдэхэд хүрсэн байна.
4. Бараа материалын болон татварын тайлан зөрүүтэй, хөрөнгө, мөнгийг анхан шатны үндсэн баримтгүйгээр зарлагадсан зөрчил нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгагдсан болон төлсөн өглөг, барагдуулсан авлагыг үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй байна.
5. Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг заавар журмын дагуу бүртгэж авдаггүй, өмч хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэдэггүй, зарим хөрөнгийг хаана, хэн ашиглаж, хариуцаж байгаа нь тодорхойгүй зэрэг нь өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих дотоодын хяналт туйлын хангалтгүй байгааг харуулж байна.

Ийнхүү “Хэнтий-Ус” ХХК-ийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнгээс үзэхэд санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт алдагдаж, хөрөнгө мөнгө зүй бусаар үрэгдэхэд хүрч, нягтлан бодох бүртгэл, тайланг санаатайгаар будлиантуулсан зөрчил болон байгууллага, иргэдийн төлсөн халаалт, цэвэр бохир усны төлбөрийн олон зуун сая төгрөгийг үр ашиг, үр дүн муутай зарцуулан, компанийг алдагдалд оруулж, санхүүгийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь компаний захирлаар ажиллаж байсан Д.Борхүү, П.Баярт-Од, Ерөнхий нягтлан бодогч Т.Батдорж нарын ажлын хариуцлага сул, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт орхигдож, үйл ажиллагаа хангалтгүй байснаас шалтгаалсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Пүрэвжавт

1. “Хэнтий Ус” ХХК-ийн хуулийн этгээдийн бүртгэлийг холбогдох хуулийн дагуу залруулж, бүртгэлийг зөв болгох нь зүйтэй байна.
2. Аймгийн ИТХ тухайн орон нутгийн өмчийн зүйлийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байхын хувьд төрийн төлөөлөлийг Орон нутгийн өмчийн албаар дамжуулан хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг хуулийн дагуу зохион байгуулах шаардлагатай байна.

Хэнтий-Ус ХХК-ний гүйцэтгэх захирал С.Бичүүгарав-т

1. Ажил гүйлгээ гарсан тухай бүрд нь анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэн бүртгэл тайланд тусгах.
2. Бараа материалыг худалдан авах, зарцуулахдаа гүйцэтгэх ажлын төсөв тооцоог гаргасны дагуу ажиллах.
3. Үйлчлүүлэгч иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс болон гэрээт иргэд, ажилчин албан хаагчдаас авах авлагын үлдэгдлүүдийг хугацаанд нь барагдуулж ажиллах.
4. Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг бүртгэлийн дугаараар коджуулж бүртгэлжүүлэх.
5. Байгууллагын хөрөнгө, мөнгөний зарцуулалтад тавих шат шатны дотоод хяналтыг эрс сайжруулж ажиллах.
6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ мөрдөж ажиллах.

ТАЙЛАН БИЧСЭН: Ахлах аудитор

Н.Туяа

Аудитор

Ү.Төгсжаргал

Шинжээч

Б.Мөнгөнцэцэг

2015 оны 9 дүгээр сарын 26

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Хэнтий-Ус ХХК-ний гүйцэтгэх захирал С.Бичүүгаравын тайлангийн төсөлтэй танилцаад манайд ирүүлсэн хариу :


**ХЭНТИЙ АЙМАГ
НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
"ХЭНТИЙ УС" ХХК**
23123 Чингис, Хэрлэн сум
Утас: 70-56-22-74, Факс: 70-56-22-74
Вэб: www.Khentii-us.mn, И-мэйл: Khentii-us@yahoo.com

2015.09.21 № 234
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Аудитын газрын 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан манай байгууллагын 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд татгалзах зүйлгүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  С.БИЧҮҮГАРАВ



АА. Н.Түвш
ш. Б.Монголдор
Санаагт аудитын
тайланг тусга.
БЭФ 12/22.
Е./Бичиг хэрэг/ ALBAN_TO

